

БҮЛЭГ V

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 5.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ
- 5.2 ТҮҮХИЙН ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ХАНДЛАГА
- 5.3 ОЛОН УЛСАД 2025 ОНД
ЗАРЛАГДСАН ИНДЕКСҮҮД

ТОЙМ

Худалдааны дайн, Украин дахь дайн болон Ойрхи Дорнодын хурцадмал нөхцөл зэрэг геополитикийн хүчин зүйлсийн нөлөөгөөр дэлхийн тодорхой бус байдал түүхэн дээд түвшинд хүрлээ. Үүний улмаас хөрөнгө оруулагчид аюулгүй хөрөнгөд хандах хандлагаа нэмэгдүүлж, алтны эрэлт өсч үнэ нэмэгдсэн бол, дэлхийн эдийн засгийн идэвхжил буурснаар нүүрсний эрэлт суларч үнэ буурав. Харин тарифын түр завсарлага болон төсвийн дэмжлэгийн бодлогын нөлөөгөөр ОУВС 2025 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг дээшлүүлэв.

БҮЛЭГ V

5.1

ДЭЛХИЙН
ЭДИЙН ЗАСАГ**87. Худалдааны дайнтай холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдлээ.**

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй өөрчлөгдөж буй энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн тодорхой бус байдлын индекс (World Uncertainty Index)-ийн үзүүлэлт 2025 оны 6 дугаар сард түүхэн дээд түвшинд хүрээд байна (Зураг 5.1).

Зураг 5.1. Дэлхийн тодорхой бус байдлын индекс

**88. ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүллээ.**

Олон Улсын Валютын сан 2025 оны төсөөллөө 7 дугаар сард 0.2 нэгж хувиар нэмэгдүүлэн 3.0 хувь болгож, 2026 оны төсөөллөө 0.1 нэгж хувиар нэмэгдүүлэн 3.1 болгон шинэчлээд байна. Энэ нь 2024 оны өсөлт 3.3 хувь ба цар тахлын өмнөх дунджаас (3.7 хувь) бага боловч 2025 оны 4-р сарын төсөөллөөс өндөр байна. Өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэхэд АНУ–Хятад тарифыг түр хугацаагаар хойшлуулсан, тариф нэмэгдэхээс өмнөх урьдчилсан худалдан авалт (front-loading) нэмэгдсэн, хөрөнгийн зах зээл сэргэсэн, АНУ, Хятад, Герман зэрэг том эдийн засгуудын төсвийн тэлэлт зэрэг нөлөөлсөн.

89. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 2 дугаар улиралд 5.2 хувиар өслөө.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт тус улсын засгийн газрын зорилтот түвшинд хүрсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байна. ОУВС 2025 оны 7 дугаар сард БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2025 онд 4.8 хувь, 2026 онд 4.2 болгож, 2025 оны 4 дүгээр сард зарласан төсөөллөөс тус тус 0.8 нэгж болон 0.2 нэгж хувиар нэмэгдүүлээд байна. Гэсэн хэдий ч худалдааны дайнтай холбоотой тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь БНХАУ-ын эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байна.

90. Евро бүсийн эдийн засаг 2024 онд 0.9 хувиар, 2025 оны 2 дугаар улиралд 1.4 хувиар өслөө.

Бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. Худалдааны дайнтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт 2025 онд 1.0 хувьд хадгалагдах бол 2026 онд бодит цалингийн өсөлт, ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр бүсийн өсөлт 1.2 хувьд хүрч эрчимжинэ гэж ОУВС тооцоолж байна.

91. Импортын өсөлт саарсны нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2025 оны 2 дугаар улиралд 2.1 хувиар тэллээ.

Худалдааны хурцадмал байдал түр намдаж, санхүүгийн зах зээл сэргэснээс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 1.9 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 2.0 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус тус 0.1 нэгж хувь болон 0.3 нэгж хувиар нэмэгдүүлээд байна. Гэсэн хэдий ч тус улсын өрнүүлж буй худалдааны дайны цар хүрээ цаашид даамжрах магадлал өндөр байгаа нь АНУ төдийгүй дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал хумигдах, инфляц өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

БҮЛЭГ V

5.2

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ХАНДЛАГА

92. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 онд 9,145 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 9,475 ам.доллар болж, өмнөх оноос 3.6 хувиар өссөн байна. АНУ-ын тарифын бодлогын шийдвэрүүдээс үүдэлтэй томоохон үйлдвэрүүдийн зэсийн нөөцийн хэлбэлзэл дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэд нөлөөлж байна. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж байгаа хэдий ч цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүч, тоон өгөгдөл боловсруулах төвүүд, технологийн салбарын хурдацтай хөгжлөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2025 онд 9,200 ам.доллар, 2026 онд 9,700 ам.долларт хүрэхээр байна.

93. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 онд 243 ам.доллар болж, өмнөх оноос 17.9 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 184 ам.доллар болж, өмнөх оноос 24.2 хувиар буурлаа. Дэлхийн коксжих нүүрсний хэрэглээний хоёрдогч том хэрэглэгч болох Энэтхэг улс руу чиглэсэн гангийн нийлүүлэлт нэмэгдсэн, БНХАУ-ын ган хайлуулах томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан зэрэг нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас шалтгаалан нүүрсний үнэ буурах дарамт нэмэгдэж байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар коксжих нүүрсний дундаж үнэ 2025-2026 онд 175 ам.долларт хүрч буурахаар байна. Монгол Улсын нүүрсний экспортын дундаж үнэ 2025-2026 онд 70 ам.доллар байхаар тооцоолж байна.

94. Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2024 онд 2,389 ам.доллар болж, өмнөх оноос 22.9 хувиар өссөн байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 3,115 ам.доллар болж, өмнөх оноос 30.4 хувиар өссөн байна. АНУ-ын Холбооны нөөцийн

банк бодлогын хүүгээ 2024 онд бууруулсан нь алтны эрэлтийг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2025 онд 2,900 ам.доллар, 2026 онд 2,800 ам.долларт хүрэхээр байна

95. Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2024 онд 110 ам.доллар болж, өмнөх оноос 8.0 хувиар буурсан байна. Харин 2025 оны эхний 7 сарын байдлаар 100 ам.доллар болж, өмнөх оноос 9.3 хувиар буурлаа. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2025 онд 95 ам.доллар, 2026 онд 90 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 2025 онд 72 ам.доллар, 2026 онд 69 ам.доллар байхаар тооцоолж байна.


96. Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 69 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 7.9 хувиар буурлаа. АНУ болон Канад, Бразил зэрэг улсуудын газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна БНХАУ-ын эрэлт бага байсан нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал, худалдааны дайнаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурах төлөвтэй. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 70 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын газрын тосны экспортын дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар, 2026 онд 72 ам.доллар байхаар тооцоолж байна.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ




Зураг 5.2. Түүхий эдийн олон улсын зах зээл дэх үнэ

1. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн гүйцэтгэл (\$/тонн)



Эх сурвалж: Блүүмберг

2. Зүүн хойд БНХАУ дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын гүйцэтгэл (\$/тонн)




Эх сурвалж: Блүүмберг

3. Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний гүйцэтгэл (\$/тонн)



Эх сурвалж: Блүүмберг

4. Brent газрын тосны гүйцэтгэл (\$/баррель)



Эх сурвалж: Блүүмберг

БҮЛЭГ V

5.3

ОЛОН УЛСАД ЗАРЛАГДСАН
ИНДЕКСҮҮД

97. Өрсөлдөх чадварын индекс: Монгол Улс 2025 онд Дэлхийн өрсөлдөх чадварын индексэд¹¹ 40.91 оноо авч 69 улсаас 65 дугаарт жагсаж, 4 байр ухарлаа. Монгол Улсын өрсөлдөх чадварын эрэмбэ буурсан нь эдийн засгийн чадамж, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг болон дэд бүтцийн бүлгийн оноо бүгд буурсантай холбоотой байна.

Хүснэгт 5.1 Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн Монгол Улсын оноо, эрэмбэ

Бүлэг	2024		2025	
	Оноо	Байр	Оноо	Байр
Эдийн засгийн чадамж	47.2▲	#42▲	44.8▼	#55▼
Засаглалын үр ашиг	35.0▲	#53▲	32.5▼	#61▼
Бизнесийн үр ашиг	20.3▲	#62▲	16.5▼	#65▼
Дэд бүтэц	14.4▲	#64▼	13.8▼	#66▼
Нэгдсэн индекс	46.3▲	#61▲	40.1▼	#65▼

Бүлэг доторх үзүүлэлтүүдийн түвшинд авч үзвэл Монгол Улс экспортын төвлөрөл (69-р байр), эдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадвар (68-р байр), төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэл (69-р байр), гадаадын хөрөнгө оруулагчдын орчин (67-р байр), хувь нийлүүлэгчийн эрхийн хамгаалалт (69-р байр), ажиллах хүчний бүтээмж (68-р байр), төр-хувийн хэвшлийн түншлэл (69-р байр), амьдралын чанар (68-р байр) зэрэг үзүүлэлтээр сүүлийн байрт эрэмбэлэгдсэн нь нийт үнэлгээг сулруулжээ.

Нөгөөтгээгүүр, эерэг өөрчлөлтүүдийн хувьд Монгол Улс хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтээр 6 байр, менежментийн туршлагын үзүүлэлтээр 2 байр ахиж, тодорхой ахиц гаргасан байна.

Бусад улсуудын эрэмбийг авч үзвэл 2025 оны тайланд Швейцар улс нэгдүгээр байрт эрэмбэлэгдсэн бөгөөд дэд бүтэц сайн, засаглалын үр ашиг өндөртэй байдал нь тэргүүлэхэд нөлөөлжээ. Мөн Сингапур, Хонконг, АНЭУ, Нидерланд зэрэг улс тэргүүлэгч байр сууриа хадгаллаа. Энэ нь Европын Холбооны улсуудын засаглал, институт, зохицуулалтын тогтолцоо нь бизнесийг дэмжихэд чиглэсэн байдагтай холбоотой байна. Мөн Сингапурт бизнес эрхлэх таатай орчин сайжирсан, гадаадын хөрөнгө оруулалт татахад хялбар, ил тод, үр ашигтай зохицуулалттай, олон улсын худалдаа хийхэд хялбар, тээвэр логистик, дэд бүтэц хөгжсөн байдал зэрэг нь өрсөлдөх чадвартай орчныг бүрдүүлсэн байна. Монгол Улсын араас Турк, Нигер, Намиби, Венесуэл улс бичигдсэн бөгөөд эдийн засаг тогтворгүй, экспортоос хараат, инфляц, улсын өрийн түвшин өндөр байдаг шалтгаанаар сүүл мушгижээ. Харин өмнөх жилүүдийн судалгаанд Монгол Улсын ард эрэмбэлэгдэж байсан Аргентин, Бразил, Перу, Гана зэрэг улс энэ жилийн тайланд манай улсын урдуур жагссан байна.

¹¹ Дэлхийн өрсөлдөх чадварын төв (IMD)-өөс жил бүр эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан нь аж ахуйн нэгжүүдэд нээлттэй өрсөлдөх орчныг бүрдүүлсэн байдлыг хэмждэг. Тус индексийг Эдийн засгийн гүйцэтгэл, Засаглалын үр ашиг, Бизнесийн үр ашиг, Дэд бүтэц гэсэн 4 бүлгийн 336 үзүүлэлтийг хамруулж 1-100 хүртэлх онооны хооронд

нэгтгэн үнэлдэг. Индекс 100-д ойртох тусам өрсөлдөх чадвар өндөр, 0-д ойртох тусам өрсөлдөх чадвар сул байна гэж үздэг. Үнэлгээний 2/3- ыг статистик мэдээлэл, үлдсэн хэсгийг удирдах албан тушаалтнуудын санал асуулгад тулгуурлан тооцдог.